



МОНГОЛ УЛС  
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 01 сарын 17 өдөр

Дугаар А/106

Номгон

Хамтарсан баг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Засгийн газрын 2023 оны 11 дүгээр тогтоолоор батлагдсан "Хүүхдийн мөнгөн тэтгэмж олгох журам", Засгийн газрын 2023 оны 01 дүгээр сарын 05 ны өдрийн 02 дугаар хуралдааны тэмдэглэлийн 2.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хүүхдийн мөнгийг өрхийн амьжиргааны түвшинтэй уялдуулан олгох болсонтой холбогдуулан мэдээлэл нь зөрүүтэй иргэдийн мэдээллийг нягтлан шалгаж, шийдвэрлэх, зөвлөгөө мэдээлэл өгөх чиг үүрэг бүхий хамтарсан багийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Хамтарсан багийн ахлагч:

Э.Энхтөр (Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Гишүүд: Э.Батцэцэг (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн)

Л.Мөнхцацрал (Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын Нийгмийн халамжийн хэлтсийн дарга)

П.Бүжинлхам (Улсын бүртгэлийн хэлтсийн Эд хөрөнгийн тасгийн дарга, Улсын ахлах бүртгэгч)

Ж.Баярмаа (Татварын хэлтсийн Бичил татвар төлөгчтэй харилцах тасгийн татварын улсын байцаагч)

Б.Ганболд (Авто тээврийн төвийн бүртгэлийн мэргэжилтэн)

Н.Догмидсанги (Нийгмийн даатгалын хэлтсийн орлого, шимтгэлийн байцаагч)

Х.Дуламсүрэн (Статистикийн хэлтсийн хүн ам хариуцсан мэргэжилтэн)

Т.Оюунгэрэл (Баянхонгор сумын Засаг даргын Тамгын газрын Худалдан авах ажиллагаа, статистик хариуцсан мэргэжилтэн)

649310254


2.

Нарийн бичгийн дарга: Б.Удвал (Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын Өрхийн мэдээллийн нэгдсэн сангийн Өргөдөл, гомдол, хүүхдийн мөнгөн тэтгэмж хариуцсан мэргэжилтэн)

2.Өрхийн мэдээллийн нэгдсэн сангийн мэдээллийн зөрүүг үнэн зөв болгох хүүхдийн мөнгөн тэтгэмжийг зорилтот бүлэгт хүргэх ажлын төлөвлөгөөг батлуулан хэрэгжүүлж, аймгийн Засаг даргын Тамгын газарт 2023 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн дотор танилцуулахыг Хамтарсан багийн ахлагч (Э.Энхтөр)-д үүрэг болгосугай.

3. Дээрх чиг үүрэг бүхий багийг орон нутгийн түвшинд байгуулж, мэдээлэл нь зөрүүтэй иргэдийн мэдээллийг нягтлан шалгаж, шийдвэрлэх, зөвлөгөө мэдээллээр хангах ажлыг шуурхай зохион байгуулж ажиллахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Б.Батсуурь)-д даалгасугай.

ДАРГА  Д.МӨНХСАЙХАН